



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

“Гар урлалын төв” –ийг нүүлгэн
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 06 сарын 27–ны өдрийн А/470 дугаар захирамж, Өмчийн харилцааны газрын даргын 2012 оны 06 сарын 22–ны өдрийн А/232 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2012 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Төмөрчний гудамжийг Баруун сэлбийн гудамжтай холбох авто зам тавих ажилтай холбогдуулан Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны Жуулчны гудамжинд байрлах үндэсний “Гар урлалын төв”–ийн 24 ширхэг сэндвич барилгыг Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, 61–ийн гарам Ташрын аманд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн /Д.Жаргалсайхан/ -д үүрэг болгосугай.

2. Нүүлгэн шилжүүлэх тээвэрлэх, угсрах ажилтай холбогдон гарах зардал 7.570.00 /долоон сая таван зуун далан мянга/ төгрөгийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын батлагдсан төсвөөс гаргахыг нягтлан /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Нүүлгэн шилжүүлэх, угсрах ажилд, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/ -д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

My Doc.\tushaal\.

115050000037